

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9.	Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12.	Шилэн дансны мэдээлэл	8
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.	Менежментийн захидал.....	9
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4.	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
ДЭХ	Дулааны эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗЭ	Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ГАНБААТАР ТАНАА

2020.03.13 № 06/815
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Багануурын дулааны станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Н.Ганбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн анхан шатны баримтыг батлагдсан маягтын дагуу хөтлөх, ажиллагсдын хэрэгцээнд худалдан авсан бараа ажил үйлчилгээнд ноогдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг суутган хасахгүй байх, татварт төлөх төлбөр хураамжийг бүрэн төлж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторовын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг тус компанид 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 1/55 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Багануурын Дулааны станц ТӨХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүний хөгжлийн дэвшилтэд технологид түшиглэн, үр ашигтай үйлдвэрлэл явуулж стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах”-д оршино.

Багануурын Дулааны станц ТӨХК -ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх;
- Дулааны эрчим хүч түгээх;
- Дулааны эрчим хүчийг зохицуулалттайгаар хангах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д заасан өөрчлөлтөөр байгууллага болон хувь хүнээс авах шимтгэл 0.5 хувиар нэмэгдсэн;
- ЭХЗХ-ны 8 дугаар сарын 29-ний өдрийн 382 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тариф 10.0 хувиар нэмэгдсэн;
- ЭХЗХ-ны 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолоор цахилгаан эрчим хүчний үнийг 35.0 хувиар, 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 454 дүгээр тогтоолоор цахилгаан эрчим хүчний үнийг тэг болгож, байгууллагад хөнгөлөлт үзүүлсэн;
- 2019 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн эрчим хүчний салбарын 3 талт хамтын хэлэлцээр, компанийн ТУЗ-ийн 8 дугаар сарын 30-ны 18 дугаар тогтоолоор ажиллагсдын цалинг 8.0-13.0 хувиар нэмэгдүүлжээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Багануурын Дулааны станц ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Багануурын Дулааны станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Багануурын Дулааны станц ТӨХК -ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд 11 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд тайлант жилийн нийт борлуулалтын орлогын дүн 5,167.7 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож 51.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшний тооцоололд өөрчлөлт ороогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Багануурын Дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,170.7 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.6	4.9	3.4
Авлага	220.0	181.4	(38.6)
Бараа материал	189.3	167.6	(21.7)
Үндсэн хөрөнгө	12,543.5	11,410.7	(1,132.8)
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	19.1	19.1
Нийт хөрөнгө	12,954.4	11,783.7	(1,170.7)
Өр төлбөр	2,401.0	1,907.1	(493.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,553.4	9,876.6	(676.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,954.4	11,783.7	(1,170.7)

Авлагын эхний үлдэгдэл 220.0 сая төгрөг байсан бол 181.4 сая төгрөг болж 38.6 сая төгрөгөөр буурсан нь оны эхэнд үлдэгдэлтэй байсан төсөвт байгууллагуудын болон “Багануур ус” ОНӨҮГ-аас авах авлага барагдсантай холбоотой байна.

Жилийн эцэст байгаа 181.4 сая төгрөгийн авлагад 143.0 сая төгрөгийн дулааны эрчим хүчний, 2016 онд дулааны эрчим хүчний төлбөрийн хоорондын тооцоогоор “Эм Дэй Ай Кей” ХХК-с 2 байрыг 52.0 сая төгрөгөөр авч байгууллагын ажилтанд борлуулсны 28.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэл, “Хөх чоно” ХХК-с кокс нийлүүлэх гэрээний дагуу авах 9.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Дулааны эрчим хүчний авлагын 103.8 сая төгрөг буюу 72.0 хувийг айл өрхөөс авах авлага, 39.2 сая төгрөгийн буюу 28.0 хувийг аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлага эзэлж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагаас авах 39.2 сая төгрөгийн авлагаас 22.7 сая төгрөгийн авлага нь 2016 оноос хуримтлагдсан, төлөгдөх хугацаа нь хэтэрсэн, хууль, шүүхийн байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн авлага, 16.5 сая төгрөгийн авлага нь тайлант жилд нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхнээс 21.7 сая төгрөгөөр буурсан нь хөдөлмөр, хамгааллын хувцас хэрэглэлийн худалдан авалтыг багасгаж, өмнөх үлдэгдлийг ашигласантай холбоотой байна. Ашиглагдахгүй байгаа 7.6 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг худалдан борлуулах тухай Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тус компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/27 тоот тушаал гарч, уг асуудлыг шийдвэрлэх шатандаа байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 12,543.5 сая төгрөг байсан ба тайлант онд өөрийн хөрөнгөөр 286.8 сая төгрөгийн их засвар, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлээр нэмэгдэж, 1,419.6 сая төгрөгийн элэгдэл тооцооллоор буурчээ.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 2,401.0 сая төгрөг байсан бол жилийн эцэст 1,907.1 сая төгрөг болж, нийт өрийг 493.9 сая төгрөгөөр бууруулжээ.

Нийт өр төлбөрийн 362.6 сая төгрөг нь Багануурын уурхай ТӨХК-д төлөх нүүрсний, 822.3 сая төгрөг нь татварын байгууллагад, 243.9 сая төгрөг нь Нийгмийн даатгалын байгууллагад, 226.7 сая төгрөг нь банкны богино хугацаатай зээлийн төлбөр, 244.3 сая төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөх өр төлбөр байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллагын борлуулалтын орлогын төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 238 дугаар тушаалаар 5,214.9 сая төгрөгөөр, зардлыг 7,093.0 сая төгрөгөөр баталсан байна.

Тус компани нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай, улсын төсвөөс жил бүр 1,100.0 сая төгрөгийн татаас санхүүжилт олгогддог, ЭХЗХ-оос байгууллагын хэрэгцээний цахилгааны төлбөрийг тодорхой хугацаагаар тэглэх, айл өрхийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын дулааны үнийг хямдруулах талаар холбогдох шийдвэрүүдийг гаргаж хөнгөлөлт үзүүлэх зэргээр үйл ажиллагааг нь дэмжин ажилладаг байна.

Багануурын дулааны станц ТӨХК нь 2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт 151.2 мян.Гкал дулаан үйлдвэрлэхээс гүйцэтгэлээр 154.8 мянган Гкал дулаан үйлдвэрлэж, төлөвлөгөөг 2.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тайлант хугацаанд 5,214.9 сая төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,167.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 47.1 сая төгрөгөөр тасарсан буюу 99.1 хувийн биелэлттэй байна. Борлуулалтын орлогын төлөвлөгөө 47.1 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар тасарсан нь Багануурын уурхай ТӨХК-ийн хэрэглээ буурсантай холбоотой байна.

Зардлын төлөвлөгөөг бизнес төлөвлөгөөнд 7,093.0 сая төгрөгөөр батлагдсанаас 7,076.6 сая төгрөгөөр гүйцэтгэж, 16.4 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Тайлант онд Эрчим хүчний сайдын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 238 дугаар тушаалаар үйл ажиллагааг 668.5 сая төгрөгийн алдагдалтай байхаар батлагдсанаас 695.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж 27.2 сая төгрөгөөр алдагдлыг нэмэгдсэн нь борлуулалтын орлогын төлөвлөгөө дутуу бүрдүүлсэнтэй холбоотой байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл тодорхойлж, 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хянан үзэж дүгнэлт гаргах, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/1153 дугаар албан бичиг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу агаарын бохирдлын төлбөр төлөгчөөр бүртгүүлж, татварыг төлж эхэлсэн талаарх асуудлыг анхаарахаар байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Багануурын Дулааны станц ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой 8, худалдан авалт түүний гүйцэтгэлтэй холбоотой 9, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн талаар 6 нийт 23 мэдээллийг хугацаанд нь байршуулжээ.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгч, зөвлөмжийн биелэлт 100.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Багануурын Дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 2.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 51.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Багануурын Дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хүчингүй болсон Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан анхан шатны баримтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг тус тус зөрчиж байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн холбогдох заавар, журмыг мөрдөөгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай" журмыг тус тус мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Шүүхийн шийдвэрт төлсөн улсын тэмдэгтийн хураамжийн буцаалтын дүнгээр зардлыг 1,750.0 мянган төгрөгөөр бууруулж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэснийг тус тус зөрчиж байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийг зөв бүртгэж бичээгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэснийг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Нэмэгдсэн өртгийн татвартай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангаар ажиллагсдын хэрэгцээнд худалдан авсан хоол, хүнс, барааны худалдан авалтыг тооцож 1,136.3 мянган төгрөгийн татварыг дутуу тооцсон байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 6.2-д заасан "хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг албан татвар суутган төлөгчийн төлөх дүнгээс хасахгүй" гэснийг зөрчиж байна.

3.3.2 Эрсдэл:

НӨАТ-ын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг мөрдөж ажиллаагүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг мөрдөж, татварын ногдуулалтыг зөв тооцож, тайлагнах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Татвартай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/1153 дугаар албан бичгийн дагуу Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9.4, 10.1-д заасан агаарын чанарын мэргэжлийн албаны дүгнэлтийг үндэслэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс тухайн жилд агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодист ногдох төлбөрийг төлөх буюу агаарын бохирдлын төлбөр төлөгчөөр бүртгүүлэх асуудлыг тайлант жилд шийдээгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Татварын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг мөрдөж ажиллаагүй байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль болон журмын дагуу татвар төлөгчөөр бүртгүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5. Дотоод аудиттай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Тайлант онд тус компанийн дотоод аудитор худалдан авах ажиллагаанд аудит хийж, дүгнэлт гаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 365 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам”-ын 2.1, 3.5, 3.7-д заасан худалдан авах ажиллагаанд дотоод аудитын нэгж нь аудит хийх, мөн хэтийн болон жилийн төлөвлөгөөнд заавал аудит хийхээр батлуулж ажиллах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Холбогдох хууль, дүрэм журам мөрдөж ажиллаагүй байх.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 365 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам”-ыг мөрдөж ажиллах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,590,323.50	4,921,514.54
1.1.2	Дансны авлага	176,801,948.66	142,953,327.09
1.1.4	Бусад авлага	43,229,056.89	38,476,160.79
1.1.6	Бараа материал	189,324,487.89	167,637,733.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	410,945,816.94	353,988,736.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	11,521,771,525.10	10,388,959,294.02
1.2.2	Биет бус хөрөнгө	1,021,721,600.00	1,021,721,600.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		19,065,964.24
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,543,493,125.10	11,429,746,858.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,954,438,942.04	11,783,735,594.31
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,398,997,372.62	595,507,738.04
2.1.1.3	Татварын өр	450,488,154.11	822,287,797.61
2.1.1.4	НДШ-ийн өглөг	118,652,691.18	243,918,698.95
2.1.1.5	Богино хугацаат зээл	400,000,000.00	226,683,738.80
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,067,423.78	278,939.23
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	14,456,359.04	1,060,800.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,383,662,000.73	1,889,737,712.63
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	17,350,850.65	17,350,850.65
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	17,350,850.65	1,907,088,563.28
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,401,012,851.38	1,907,088,563.28
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: төрийн	6,291,517,841.35	6,291,517,841.35
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,652,391,027.32	2,652,391,027.32
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,601,190,162.12	8,601,190,162.12
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-6,991,672,940.13	-7,668,451,999.76
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,553,426,090.66	9,876,647,031.03
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,954,438,942.04	11,783,735,594.31

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,998,420,779.59	5,167,747,211.95
2	Борлуулалтын өртөг	5,919,226,023.77	6,412,365,223.06
3	Нийт ашиг(алдагдал)	-920,805,244.18	-1,244,618,011.11
4	Түрээсийн орлого	4,066,400.00	4,066,400.00
5	Хүүгийн орлого	658,503.16	616,991.96
8	Бусад орлого	1,127,031,139.08	1,108,416,711.31
10	Ерөнхий ба удирдлагын зардал	277,172,919.96	343,734,695.50
11	Санхүүгийн зардал	68,482,931.21	81,722,028.38
17	Бусад ашиг (алдагдал)	-37,200,738.84	-138,808,692.96
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-171,905,791.95	-695,783,324.68
19	Орлогын татварын зардал	479,064.79	-19,004,265.05
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-172,384,856.74	-676,779,059.63
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-172,384,856.74	-676,779,059.63
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,057,011,540.25	5,038,467,198.08
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,747,444,138.46	3,638,644,219.62
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	14,711,463.00	27,878,500.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,100,000,000.00	1,100,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	194,855,938.79	271,944,478.46
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,721,220,822.46	4,450,835,695.89
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,779,132,180.89	2,050,888,982.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	439,868,789.74	488,355,305.57
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	271,142,159.95	214,143,446.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	994,364,746.09	484,022,242.69
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	361,852,264.79	452,429,662.13
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	60,487,113.02	67,018,059.66
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	389,387,101.66	294,923,953.11
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,475,093.00	3,736,208.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	418,511,373.32	395,317,835.81
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	335,790,717.79	587,631,502.19
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	658,503.16	616,991.96
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	658,503.16	616,991.96
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	455,419,180.33	344,761,893.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	455,419,180.33	344,761,893.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	454,760,677.17	344,144,901.04
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	400,000,000.00	427,720,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	400,000,000.00	427,720,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	300,000,000.00	667,875,410.11

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	300,000,000.00	667,875,410.11
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	100,000,000.00	240,155,410.11
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	18,969,959.38	3,331,191.04
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,560,282.88	1,590,323.50
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,590,323.50	4,921,514.54

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,291,517,841.35	697,879,621.79	7,579,468,562.00	-6,819,288,083.39	7,749,577,941.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл	6,291,517,841.35	697,879,621.79	7,579,468,562.00	-6,819,288,083.39	7,749,577,941.87
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				-172,384,856.74	-172,384,856.74
Өмчид гарсан өөрчлөлт			1,021,721,600.00		1,021,721,600.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		1,954,511,405.53			1,954,511,405.53
2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	6,291,517,841.35	2,652,391,027.32	8,601,190,162.00	-6,991,672,940.13	10,553,426,090.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл	6,291,517,841.35	2,652,391,027.32	8,601,190,162.00	-6,991,672,940.13	10,553,426,090.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-676,779,059.63	-676,779,059.63
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	6,291,517,841.35	2,652,391,027.32	8,601,190,162.00	-7,668,451,999.76	9,876,647,031.03

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн</i>	Аудитын код:
2020			САГ-2020/6/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:	Багануурын дулааны станц ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог, нэр
	1	2	3	4	5
1	Хүчингүй болсон Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан анхан шатны баримтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлсөн.	0.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, СЭЗБХ-ийн дарга	Н.Ганбаатар Ц.Энхцэцэг
2	Шүүхийн шийдвэрт төлсөн улсын тэмдэгтийн хураамжийн буцаалтын дүнгээр зардлыг 1.7 сая төгрөгөөр бууруулж бүртгэсэн.	1.7	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, СЭЗБХ-ийн дарга	Н.Ганбаатар Ц.Энхцэцэг
3	Татварын цахим төлбөрийн баримтын системд оруулсан нэмүү өртгийн албан татварын тайланд ажиллагсдын хэрэгцээнд худалдан авсан хоол, хүнс, барааны 1.1сая төгрөгийг татвараас хасч тооцсон.	1.1	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, СЭЗБХ-ийн дарга	Н.Ганбаатар Ц.Энхцэцэг
4	Тайлант онд тус компанийн дотоод аудитор худалдан авах ажиллагаанд аудит хийж, дүгнэлт гаргаагүй.	0.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, СЭЗБХ-ийн дарга	Н.Ганбаатар Ц.Энхцэцэг
5	Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/1153 дугаар албан бичгийн дагуу Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9.4, 10.1-д заасан агаарын чанарын мэргэжлийн албаны дүгнэлтийг үндэслэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс тухайн жилд агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодист ногдох төлбөрийг төлөх буюу агаарын бохирдлын төлбөр төлөгчөөр бүртгүүлэх асуудлыг тайлант жилд шийдвэрлээгүй байна	0.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, СЭЗБХ-ийн дарга	Н.Ганбаатар Ц.Энхцэцэг
	Дүн	2.8			

